МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 07 өдөр    Дугаар А/121    Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.6, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.16 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Боловсрол, шинжлэх ухааны сайд болон аймгийн Засаг даргын хооронд 2022 онд орон нутагт боловсрол, шинжлэх ухааны салбарын чиг үүргийг хэрэгжүүлэх, хамтран ажиллах гэрээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд шинжлэх ухаан, технологи, инновацийн үйл ажиллагааг дэмжин ажиллах чиг үүрэг бүхий Засаг даргын дэргэдэх Шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөлийг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

| | |
|---|---|
| Ажлын хэсгийн дэд дарга: | Аймгийн Засаг даргын орлогч |
| | Нийгмийн бодлогын хэлтсийн дарга |
| | Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга |
| | Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга |
| | Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга |
| | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга |
| | Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга |
| | Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга |
| | Соёл, урлагийн газрын дарга |
| | Политехникийн коллежийн захирал |
| Нарийн бичгийн дарга: | Боловсрол, шинжлэх ухааны газрын Инноваци, шинжлэх ухааны асуудал хариуцсан мэргэжилтэн |

2. Аймаг, орон нутагт шинжлэх ухаан инноваци, технологийг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулан шаардагдах зардлыг орон нутгийн жил бүрийн төсөвт тусган шийдвэрлүүлж ажиллахыг ажлын хэсгийн дэд даргад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА    Ц.ЧОГСОМЖАВ

231010333